

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2026/010/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ СУМЫН НАРНЫ ХААН
ЦОГЦОЛБОР ЦЭЦЭРЛЭГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2026 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор: Б.Адъяасүрэн

Утас: 70273204 Цахим хаяг: adiyasuren@audit.gov.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн:

Уваа уул аудит ХХК захирал: Ч.Мөнхтуяа

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025.02.25 № 01/2025
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН УГТААЛЦАЙДАМ
СУМЫН НАРНЫ ХААН ЦОГЦОЛБОР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Л.ЦЭРЭННАДМИД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Угтаалцайдам сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр 21,510.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 19,624.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил акталж, данс бүртгэлээс хассан.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын зөвшөөрөлгүй 335,683.3 мянган төгрөгийн барилга байгууламж, 11,814.0 мянган төгрөгийн газар эзэмших эрх нийт 347,497.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Угтаалцайдам сумын Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлснийг санхүүгийн тайланд залруулга хийсэн.

4126020253

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт бүхий нийт 38 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 92.7 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	143,426,597.36	93,317,605.35
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	99,337,413.36	37,817,929.35
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	99,337,413.36	37,817,929.35
3121	Төгрөг	99,337,413.36	37,817,929.35
31211	Төрийн сангийн харилцах	99,337,413.36	37,817,929.35
35	БАРАА МАТЕРИАЛ	44,089,184.00	55,499,676.00
351	Түүхий эд материал	44,089,184.00	55,499,676.00
35110	Тусгай зориулалттай материал	44,089,184.00	55,499,676.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,652,838,789.43	2,591,253,338.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,652,838,789.43	2,591,253,338.18
392	Биет хөрөнгө	2,621,032,789.43	2,559,337,338.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,634,614,701.61	2,634,614,701.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	(104,343,925.55)	(159,048,397.91)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	69,821,952.00	57,419,700.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(41,159,909.98)	(28,419,850.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	90,707,196.69	71,698,768.69
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,451,225.34)	(17,771,583.79)
39214	Бусад үндсэн хөрөнгө	844,000.00	844,000.00
393	Биет бус хөрөнгө	31,806,000.00	31,916,000.00
39301	Програм хангамж	150,000.00	110,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(150,000.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	31,806,000.00	31,806,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,796,265,386.79	2,684,570,943.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,915,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,915,000.00	-
413	Өглөг	2,915,000.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,915,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,793,350,386.79	2,684,570,943.53
51	Засгийн газрын хувь оролцоо	2,793,350,386.79	2,684,570,943.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	68,657,009.58	68,657,009.58
51101	Өмч: - төрийн	68,657,009.58	68,657,009.58
512	Хуримтлагдсан үр дүн	2,600,558,780.03	2,494,979,336.77
51210	Өмнөх үеийн үр дүн	2,600,558,780.03	2,603,758,780.03
51220	Тайлант үеийн үр дүн	-	(108,779,443.26)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	124,134,597.18	120,934,597.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,796,265,386.79	2,684,570,943.53

Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,344,549,889.53	1,042,775,236.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,399,933,563.53	9,108,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,375,592,063.53	9,108,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,375,592,063.53	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,375,592,063.53	-
122	Тусламжийн орлого	24,341,500.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	24,341,500.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	944,616,326.00	1,033,667,236.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	868,216,100.00	943,022,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	868,216,100.00	943,022,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,400,226.00	90,644,536.20
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,400,226.00	90,644,536.20
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,009,711,998.13	1,151,554,679.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,009,711,998.13	1,151,554,679.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,009,711,998.13	1,141,547,779.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,957,915.29	780,641,714.27
210101	Үндсэн цалин	413,381,909.29	469,652,703.70
210102	Нэмэгдэл	244,403,683.70	278,753,286.42
210104	Урамшуулал	24,172,322.30	32,235,724.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,922,520.49	88,679,969.74
210201	Тэтгэврийн даатгал	58,501,352.06	58,640,187.74
210202	Тэтгэмжийн даатгал	6,850,404.58	7,511,970.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,448,259.21	3,756,985.25
210204	Ажилгүйдлийн даатгал	3,448,259.21	3,756,985.25
210205	Эрүүл мэндийн даатгал	13,674,245.43	15,013,841.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,126,859.00	87,644,536.20
210301	Гэрэл, цахилгаан	7,448,137.45	13,745,853.20
210302	Түлш, халаалт	42,408,120.99	72,817,943.00
210303	Цэвэр, бохир ус	270,600.56	1,080,740.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,429,071.00	9,645,920.00
210401	Бичиг хэрэг	2,034,000.00	3,953,920.00
210402	Тээвэр, шатахуун	10,007,557.00	5,692,000.00
210408	Бараа материал акталсны зардал	17,387,514.00	-
2105	Нормативт зардал	83,705,400.00	86,535,000.00
210502	Хоол, хүнс	83,705,400.00	84,981,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,347,200.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	22,347,200.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,333,600.00	3,922,190.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,333,600.00	3,922,190.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	53,889,432.35	81,478,449.25

**Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,615,660.00	7,500,088.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,761,400.00	2,558,910.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	39,512,372.35	71,419,451.25
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	10,006,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	10,006,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	10,006,900.00
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,279,000.00	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	9,279,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(9,279,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,325,558,891.40	(108,779,443.26)

Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	944,616,326.00	1,033,667,236.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	944,616,326.00	1,033,667,236.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	868,216,100.00	943,022,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	868,216,100.00	943,022,700.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	76,400,226.00	90,644,536.20
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	76,400,226.00	90,644,536.20
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	963,601,892.92	1,094,460,720.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	963,601,892.92	1,094,460,720.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	963,601,892.92	1,084,453,820.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	681,957,915.29	780,641,714.27
210101	Үндсэн цалин	413,381,909.29	469,652,703.70
210102	Нэмэгдэл	244,403,683.70	278,753,286.42
210104	Урамшуулал	24,172,322.30	32,235,724.15
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,846,051.63	88,679,969.74
210201	Тэтгэврийн даатгал	58,424,883.20	58,640,187.74
210202	Тэтгэмжийн даатгал	6,850,404.58	7,511,970.50
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,448,259.21	3,756,985.25
210204	Ажилгүйдлийн даатгал	3,448,259.21	3,756,985.25
210205	Эрүүл мэндийн даатгал	13,674,245.43	15,013,841.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,400,226.00	87,644,536.20
210301	Гэрэл, цахилгаан	7,448,137.45	13,745,853.20
210302	Түлш, халаалт	42,408,120.99	72,817,943.00
210303	Цэвэр, бохир ус	4,543,967.56	1,080,740.00
2105	Нормативт зардал	87,637,600.00	87,896,600.00
210502	Хоол, хүнс	87,637,600.00	87,896,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,000,000.00	3,000,000.00
210604	Урсгал засвар	22,000,000.00	3,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,333,600.00	4,148,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,333,600.00	4,148,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,426,500.00	32,442,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,000,500.00	25,343,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,426,000.00	7,098,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		10,006,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		10,006,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		10,006,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(18,985,566.92)	(60,793,484.01)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	550,000.00	726,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	550,000.00	726,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	550,000.00	726,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	550,000.00	726,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(550,000.00)	(726,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(19,535,566.92)	(61,519,484.01)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	118,872,980.28	99,337,413.36
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	99,337,413.36	37,817,929.35

Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,657,009.58	124,134,597.18	274,999,888.63	467,791,495.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,657,009.58	124,134,597.18	274,999,888.63	467,791,495.39
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	2,325,558,891.40	2,325,558,891.40
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,657,009.58	124,134,597.18	2,600,558,780.03	2,793,350,386.79
2015 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,657,009.58	124,134,597.18	2,600,558,780.03	2,793,350,386.79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	123,785,229.18	123,785,229.18
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,657,009.58	124,134,597.18	2,724,344,009.21	2,917,135,615.97
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	- 123,785,229.18	00.00	-123,785,229.18
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(108,779,443.26)	(108,779,443.26)
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,657,009.58	349,368.00	2,615,564,565.95	2,684,570,943.53

Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,037,531,600.00	1,033,667,236.20	3,864,363.80	99.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	91,648,800.00	90,644,536.20	1,004,263.80	98.9
132001	Орон нутгийн төсвөөс	91,648,800.00	90,644,536.20	1,004,263.80	98.9
1310	УЛСЫН ТӨВЛӨРСӨН САНХҮҮЖИЛТ	945,882,800.00	943,022,700.00	2,860,100.00	99.7
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	945,882,800.00	943,022,700.00	2,860,100.00	99.7
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,127,354,800.00	1,095,186,720.21	32,168,079.79	97.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,127,354,800.00	1,095,186,720.21	32,168,079.79	97.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,127,354,800.00	1,095,186,720.21	32,168,079.79	97.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	797,741,900.00	775,433,252.76	22,308,647.24	97.2
210101	Үндсэн цалин	486,305,500.00	462,091,029.96	24,214,470.04	95.0
210102	Нэмэгдэл	279,902,900.00	281,106,498.65	(1,203,598.65)	100.4
210104	Урамшуулал	31,533,500.00	32,235,724.15	(702,224.15)	102.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,936,600.00	93,888,431.25	5,048,168.75	94.9
210201	Тэтгэврийн даатгал	67,150,800.00	63,848,649.25	3,302,150.75	95.1
210202	Тэтгэмжийн даатгал	7,946,500.00	7,511,970.50	434,529.50	94.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,973,200.00	3,756,985.25	216,214.75	94.6
210204	Ажилгүйдлийн даатгал	3,973,200.00	3,756,985.25	216,214.75	94.6
210205	Эрүүл мэндийн даатгал	15,892,900.00	15,013,841.00	879,059.00	94.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,648,800.00	87,644,536.20	1,004,263.80	98.9
210301	Гэрэл, цахилгаан	15,830,800.00	13,745,853.20	2,084,946.80	86.8
210302	Түлш, халаалт	72,818,000.00	72,817,943.00	57.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	0.00	1,080,740.00	(1,080,740.00)	
2105	Нормативт зардал	91,703,500.00	87,896,600.00	3,806,900.00	95.8
210502	Хоол, хүнс	91,703,500.00	87,896,600.00	3,806,900.00	95.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,148,600.00	4,148,600.00	-	100.0
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	4,148,600.00	4,148,600.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,168,500.00	33,168,400.00	100.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	26,070,000.00	26,069,900.00	100.00	100.0
210902	Сургалт, дадлага, бэлтгэлийн зардал	7,098,500.00	7,098,500.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,006,900.00	10,006,900.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шаг урам	10,006,900.00	10,006,900.00	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		99,337,413.36		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		37,817,929.35		

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 376,982.6 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцооллын 3 алдаа илэрснийг аудитын явцад бүрэн залруулав. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 10,068.3 мянган төгрөгийн худалдан авсан үндсэн хөрөнгийг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнаагүй.
- Үнэ төлбөргүй авсан шилжүүлэн авсан 1,200.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан материалаар бүртгэсэн.
- Төв аймгийн Орон нутгийн өмчийн газрын шийдвэргүй 335,683.3 мянган төгрөгийн барилга байгууламж, 11,814.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг балансаас балансад шилжүүлсэн.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд хандиваар авсан 18,217.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй авсан орлогоор бүртгэснийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна”, 15.2 “нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 830.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 830.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 93,266.9 мянган төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна", 8.1.5 "Санхүүгийн тайлангийн тодруулга", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.3 "Санхүүгийн тайлангийн тодруулга нь Санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд толилуулаагүй боловч тэдгээрийн аль нэгийг ойлгоход хамааралтай нэмэлт мэдээллээр хангана" гэж заасантай тус тус нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг тайлбар тодруулгын хамт бэлтгэж байх зөвлөмж өгөв.

2. Зардлын дансны асуудал холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг батлагдсан норматив, хүүхдийн ирцтэй тулган шалгахад тогтоосон нормативаас 830.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Энэ нь Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 237 тоот тогтоолоор батлагдсан "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" гэж заасантай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон журмыг дагуу олгох.

3. Тооллогын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын даргын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/22 дугаар тушаалаар эд хөрөнгийн тооллого хийхээр тооллогын комиссыг томилж, тооллого хийгдсэн боловч тооллогын тайлан, тооцоо бодсон акт үйлдээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4 "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" 73 дугаар зүйлийн 73.2 "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулж, тооцоог бодож, тооллогын явц, үр дүнг удирдлагад танилцуулж байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнгөн гүйлгээний тайланд худалдан авсан 10,068.3 мянган төгрөгийн худалдан авсан үндсэн хөрөнгийг биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардалд тайлагнаагүй.	1	10,068.3			1	10,068.3	1	10,068.3		
2	Үнэ төлбөргүй авсан шилжүүлэн авсан 1,200.0 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан материалаар бүртгэсэн.	1	1,200.0			1	1,200.0	1	1,200.0		
3	Санхүүгийн үр дүнгийн тайланд хандиваар авсан 18,217.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй авсан орлогоор бүртгэснийг.	1	18,217.0			1	18,217.0	1	18,217.0		
4	Төв аймгийн Орон нутгийн газрын өмчийн шийдвэргүй 335,683.3 мянган төгрөгийн барилга байгууламж, 11,814.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг балансас балансад шилжүүлсэн.	1	347,497.3			1	347,497.3	1	347,497.3		
	Дүн	4	376,982.6			4	376,982.6	4	376,982.6		

Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг батлагдсан норматив, хүүхдийн ирцтэй тулган шалгахад тогтоосон нормативаас 830.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.	1	830.2					1	830.2						
2	Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын дагуу Санхүүгийн тайлангийн мэдээлэл агуулсан тодруулга тайлан бэлтгээгүй байна.	1	-			-	-	1	-						
3	Байгууллагын даргын 2025 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/22 дугаар тушаалаар эд хөрөнгийн тооллого хийхээр тооллогын комиссыг томилж, тооллого хийгдсэн боловч тооллогын тайлан, тооцоо бодсон акт үйлдээгүй байна.	1						1							
	Дүн	3	830.2					3	830.2						

Төв аймгийн Угтаалцайдам сумын Нарны хаан цогцолбор цэцэрлэгийн
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 171 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 164 мэдээлэл, хугацаа хоцорч мэдээлсэн 7 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 747,661.1 мянган төгрөгийн 14 гүйлгээ хугацаа хоцорч, зарлагын 42,424.4 мянган төгрөгийн 2 гүйлгээ байршуулаагүй.	1	790,085.5					1	790,085.5
Нийт дүн	1	790,085.5					1	790,085.5

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn